

БАТЛАВ

УЛААНБААТАР ЦАХИЛГААН ТҮГЭЭХ  
СҮЛЖЭЭ ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРАЛ



Д.БАЯРСАЙХАН

2019 оны ... сарын ...-ны өдөр

БАТЛАВ

“ЭРЧИМ ХАЙРХАН”  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



ХХК-ИЙН

Д.ГАНТУЯА

2019 оны !! сарын !!..-ны өдөр

**“ГЭРЭЛГҮЙ АЙЛ ӨРХИЙГ ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧЭЭР ХАНГАХ АЖИЛ”-ЫН  
БАГЦ-7 ТӨВ АЙМАГ БАТСҮМБЭР СУМ БИЧИГТИЙН ГЭРЭЛ ЦАХИЛГААНГҮЙ АЙЛ  
ӨРХҮҮДИЙН ГАДНА ЦАХИЛГААН ХАНГАМЖИЙН АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ**

Дугаар 2019/431

2019 оны 11 дүгээр сарын 18

Улаанбаатар хот

Нэг талаас Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас “ЭРЧИМ ХАЙРХАН” ХХК (цаашид “гүйцэтгэгч” гэх), дараах зүйлийг харилцан тохиролцож 2019 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний, Барилгын болон бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж шилжүүлэн барих, тоног төхөөрөмж суурилуулахтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь Төв аймаг Батсүмбэр сум Бичигтийн гэрэл цахилгаангүй айл өрхүүдийн гадна цахилгаан хангамжийн ажил (цаашид “ажил” гэх)-ыг 119,247,918.0 (нэг зуун арван есөн сая хоёр зуун дөчин долоон мянга есөн зуун арван найм) төгрөг (цаашид “гэрээний үнэ” гэх)-өөр гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Гэрээний үнэ 119,247,918.0 (нэг зуун арван есөн сая хоёр зуун дөчин долоон мянга есөн зуун арван найм) төгрөг байна. 2019-2020 онд 119,247,918.0 (нэг зуун арван есөн сая хоёр зуун дөчин долоон мянга есөн зуун арван найм) төгрөг байх бөгөөд захиалагч өөрийн хөрөнгөөр санхүүжилтийг дараах байдлаар санхүүжүүлнэ.

А. Ажил дууссаны дараа гэрээ дүгнэсэн протокол баталгаажсанаар чанарын баталгаа, зүгшрүүлэх тохируулах хугацааны барьцаа хөрөнгө болон төсөвт тусгагдсан холбогдох бусад зардлыг хасан үлдэгдэл санхүүжилтийг олгоно.

4. Гүйцэтгэгч нь Төв аймаг Батсүмбэр сум Бичигтийн гэрэл цахилгаангүй айл өрхүүдийн гадна цахилгаан хангамжийн ажлыг 2019 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр эхэлж, 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор ашиглалтад оруулна.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх).  
Үүнд:

- 5.1. Гэрээ байгуулах эрх олгосон тухай мэдэгдэл; үнийн санал,
- 5.2. Гэрээний тусгай нөхцөл;
- 5.3. Гэрээний ерөнхий нөхцөл;
- 5.4. Төсөв, зураг;
- 5.5. Үе шатны ажлын хуваарь;
- 5.7. Бусад шаардлагатай баримт бичиг ;

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг, хариуцлагыг хүлээнэ.

6. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хариуцлагыг хүлээж байна.

7. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг хүлээж болно.

8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр боон утсан холбоогоор харилцана.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

“УБЦТС” ТӨХК-ИЙН НИЙТЛЭГ ҮЙЛ  
АЖИЛЛАГАА ЭРХЭЛСЭН ДЭД  
ЗАХИРАЛ

 О.ОТГОНБАЯР

САНХҮҮ БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН  
ДАРГА

 О.АРИУНБОЛД

ХАНГАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАНЫ  
ДАРГА

 Ш.ОЮУНЧИМЭГ

ХУУЛИЙН МӨРГЭЖИЛТЭН

 Ц.ЭНХЦЭЦЭГ

**ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**



Д.ГАНТУЯА

Утас: 99116881, 95098009

Факс:

Хаяг: ЧД дүүрэг, 2-р хороо, их тойруу-  
15, ренталон ХХК-ийн барй 214 тоот.